

ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАСГИЙН ДАРГА С.БАТЦЭНГЭЛИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6		7
<b>ЗОРИЛТ 1. “НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧЛАХ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХАМРАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЖ, ШИМТГЭЛИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ БИЕЛҮҮЛЭХ</b>							
1.	1.1. Ажил олгогч, даатгуулагчдад Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн талаар зөвлөгөө өгөх.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	Ажил олгогч даатгуулагчийн нийгмийн даатгалын тухай хуулийн мэдлэг нэмэгдсэн байна.	Бор-Өндөр сумын үйл ажиллагаа явуулж байга 80 гаруй ажил олгогч, нягтлан нябо нарт болон 1-6 багийн иргэд, даатгуулагчдад Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн талаарх заавар, зөвлөгөө мэдээллийг цахимаар болон утсаар, ажлын байран дээрээ өгч ажиллаж байна. Сумын хэмжээнд нийтдээ 7 удаагийн нээлттэй хаалганы өдөрлөгөөр дамжуулан нийт 808 даатгуулагчдад зөвлөгөө мэдээллийг хүргэн ажилласан.	2025.01.01-2025.06.30	100
	1.2. Нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаар ажил олгогч даатгуулагчдад мэдээлэл өгч, сургах.	Даатгуулагчдын мэдлэг дээшилсэн байна.	Нийгмийн даатгалын цахим систем portal.ndaatgal.mn цахим хуудас болон NDaatgal гар утасны программын талаар зөвлөмж хүргэсэн байна.	Даатгуулагчдын нийгмийн даатгалын цахим үйлчилгээний талаарх мэдлэг дээшилсэн байна.	Нийгмийн даатгалын цахим үйлчилгээ portal.ndaatgal.mn хаягаар ажил олгогч нар НД7,8 тайланг илгээх, ашиглах, даатгуулагч сайн дурын даатгалын гэрээ байгуулах, шимтгэл төлөх, ажилгүйдэл болон жирэмсэн амаржсаны тэтгэмжийн хүсэлт илгээх, тэтгэмж олголтын хуваарь харах заавар зөвлөмжийг өгч мэдээллийг цаг тухайд нь мэдээллээр хангаж цахимаар хүсэлт хүлээн авч байна. 2025 оны 01-06 сарын байдлаар 5 сайн дурын даатгуулагчаас хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, 47 даатгуулагчаас жирэмсэний болон амаржсаны тэтгэмж, 36 даатгуулагчаас ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн. Мөн 80 ажил олгогчдод portal.ndaatgal.mn цахим хаягаар бүртгүүлэх, шинээр ажилтан бүртгэх, ажлаас чөлөөлөх, тушаалыг тайланд оруулах, тоон гарын үсгээр тайлан илгээх заавар зөвлөмжийг өгч цахимаар тайлан хүлээн авч баталтгаажуулсан. 21 ажил олгогчийн 861 даатгуулагчийн эмнэлгийн хуудсыг илгээх, буруу илгээгдсэн тэтгэмжийг эмнэлэгийн байгууллага болон ажил олгогчоор тухай бүрд нь засварлуулж хүлээн авч олгоод байна.	2025.01.01-2025.06.30	100
	1.3. Шинээр байгуулагдсан болон нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийсэн ажил олгогчийг нийгмийн даатгалд хамруулах.	Хамрах хүрээг нэмэгдүүлсэн байна.	Шинээр ажил олгогчийн тоог 6, даатгуулагчийн тоог 29 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	Шинээр 5 ажил олгогч, 18 даатгуулагч хамруулсан байна.	Татвар бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагыг нийгмийн даатгалд бүртгүүлэх зааврын дагуу холбогдох материалыг бүрдүүлэн авч нийт 6 аж ахуйн нэгж байгууллагыг шинээр хамруулсан. Нийт 41,5 сая төгрөгийн цалингийн сантай 6 ажил олгогчийн хамруулсан байна. Үүнд: ТОГТУУН ТЭМҮҮЛЭЛ, ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН ХҮҮХДИЙН ДӨРӨВДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГ, СОД ТӨГС ЖАРГАЛ УРЛАН ХОРШОО, ЗООСТ АЛАГ ХОРШОО, БАЯЛАГ	2025.01.01-2025.06.30	100

					БАТӨНДӨР ТӨГӨЛ ХОРШОО, ТЭНҮҮН ХУРАН ХАН ААН-ийг бүртгэж хамруулсан. 2024 онд улсын бүртгэлийн гэрчилгээ авсан нийгмийн даатгалд бүртгүүлээгүй аж ахуй нэгж, хоршоо, нөхөрлөл, төрийн бус байгууллагуудын захирал эзэнтэй холбогдож Нийгмийн даатгалын ерөнхий хууль тогтоомжийн дагуу ажил олгогч улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш ажлын 14 өдрийн дотор харьяалагдах нийгмийн даатгалд нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх талаар мэдээллийг хүргэсэн бөгөөд 11 байгууллагаас холбогдох баримт бичгийг бүрдүүлэн авч ажил олгогчоор бүртгэж дугаар олгон үйл ажиллагаа явуулаагүй байгаа ажил олгогчийг цахимаар Х тайлан гаргуулан сар бүрэн тайлан хүлээн авч 3 байгууллага нь үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа тул нийгмийн даатгалын тайлан илгээж шимтгэл төлж байна.		
1.4. Ажил олгогч, дааттуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийн цахим тайлан, тооцоог хянаж, баталгаажуулах.	Нийгмийн даатгалын тайланг хугацаанд бүрэн хүлээн авна.	77 Ажил олгогчийн НДШ-ийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авч, мэдээллийг бүрэн зөв мэдээллийн санд бүртгэж, тайлан мэдээг хугацаанд нь гаргасан.	Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авсан байна.	2025 оны 1-6 сарын байдлаар нийт 80 ажил олгогч, байгууллагын НД7,8 тайланг цахимаар хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан. Ажил олгогч, байгууллагуудын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг улирал, хагас жил гаргаж өр авлагын мэдээ тайланг сар бүр гаргаж барагдуулан ажиллаж байна. Нийт ажил олгогч, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл 12,079,374.16 мянган төгрөгийн орлогын хуримтлуулснаас урьд оны авлага 1,202,008.22 мянган төгрөг байна. Тоон гарын үсгээр 21 ажил олгогчийн НД7, НД8 тайлан илгээж баталгаажуулсан шинээр 6 байгууллага тоон гарын үсгээр тайлангаа илгээх хүсэлт ирүүлээд байна.	2025.01.01-2025.06.30	100	
1.5. Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлагыг барагдуулан ажиллах.	Шинээр шимтгэлийн авлага үүсгэхгүй ажиллана.	Шимтгэлийн авлага үүсгэсэн 14 байгууллагатай холбогдож 2547092,95 төгрөгийн өр авлагыг барагдуулж өмнөх оны өрийг 96,1%-иар бууруулсан.	Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэхгүй ажилласан байна.	Урьд оны буюу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 13 ажил олгогч, байгууллагын 1,293,826.71 мянган төгрөгийн өр авлагаас 1,202,008.22 мянган төгрөгийг барагдуулж өмнөх оны өр авлагыг 92.9% хувиар бууруулан ажилласан. Сар бүр НДШимтгэлийн тайлан хүлээн авч нийгмийн даатгалын шимтгэлээ шилжүүлээгүй буюу төлөлтөнд хяналт тавьж ажил олгогч байгууллагуудтай холбогдон шимтгэлээ сардаа багтаан төлөхийг сануулах, өр авлага үүсгэсэн бол тухайн сард төлөхийг улсаар мэдэгдэх, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэх, банкин дахь харилцах дансанд улсын байцаагчийн мэдэгдлээр харилцах дансны барилт хийн үл маргах журмаар төлүүлэх, уулзалтын тэмдэглэл хөтлөх, шимтгэлээ төлж барагдуулах хуваарь гаргуулах; хууль хяналтын байгууллагад хандах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажилласан. Өмнөх оны өр авлагаас барагдаагүй үлдсэн 92,718.49 төгрөгөөс 1 ажил олгогчтой уулзалтын тэмдэглэл байгуулсан, 2 ажил олгогч байгууллагын 15979.79 төгрөгийн өр авлагыг барагдуулахаар шүүхэд материал бүрдүүлж өгсөн байна.	2025.01.01-2025.06.30	92.9	
1.6. Дааттуулагчтай сайн дурын даатгалын гэрээ байгуулан, шимтгэлийг төлүүлэх	Нийгмийн даатгалын хамралт нэмэгдсэн байна.	Шинээр 89 дааттуулагчийг сайн дурын даатгалд хамруулсан байна.	Журамд заасны дагуу сайн дурын даатгалын гэрээ байгуулан, шимтгэлийг төлүүлсэн байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар шинээр 33 хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэнийг сайн дурын даатгалд хамруулсан. 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан 792,0-с бага цалингийн сангаар сайн дурын даатгал төлж байсан иргэдийн шимтгэл төлөлтийг шүүж дутуу төлөгдсөн 14 дааттуулагчидтай улсаар холбогдон мэдээлэл өгч, зөрүүг төлүүлж, цаашид шимтгэлээ	2025.01.01-2025.06.30	100	

					бүрэн хугацаандаа төлөх талаарх мэдээллийг өгсөн. Нийт 241 даатгуулагчийн 83,360.94 мянган төгрөгийн шимтгэлийн орлогыг нийгмийн даатгалын санд хуримтлуулсан байна.		
1.7.	Малчин, 0-3 насны хүүхэдтэй эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийг сайн дурын даатгалд хамруулах.	Бүрэн хамрагдсан байна.	Сайн дурын даатгалд хамрагдаагүй иргэдийн судалгаанд үндэслэн даатгуулагчтай холбогдон малчин 23 даатгуулагч, 0-3 насны хүүхэдтэй эх 25 даатгуулагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эх 6 даатгуулагчийг сайн дурын даатгалд хамруулсан.	Малчин 6, 0-3 насны хүүхэдтэй эх 12, ХХЭ 9, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхчүүдийг дурын даатгалд бүрэн хамруулсан байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар малчны сайн дурын даатгалд 10 даатгуулагч, 0-3 насны хүүхдээ асарч буй эхийн сайн дурын даатгалд 6 даатгуулагч, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй ажил хөдөлмөр эрхлээгүй эцэг, эхийн сайн дурын даатгалд 2 даатгуулагчийг тус тус шинээр хамруулсан. 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан даатгуулагчдын шимтгэл төлөлтийг сар бүр шүүж даатгуулагчтай холбогдон зөрүүг төлүүлсэн. Нийт 121 даатгуулагчийн 21,009.65 мянган төгрөгийн шимтгэлийн орлогыг нийгмийн даатгалын санд хуримтлуулсан.	2025.01.01-2025.06.30	80
1.8.	Улсын байцаагчийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавин ажиллах.	Хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.	1. ҮО-ын тэтгэмж 4568152, 2.тэтгэмж 154878, 3.ажилгүйдэл 1310037, 4.оршуулга 2000000, 5.ҮО тэтгэвэр 3779832 Нийт 11812899 төгрөгийн авлагыг хугацаанд нь барагдуулсан байна.	Улсын байцаагчийн акт, албан шаардлагаар ногдуулсан төлбөр зөрчлийг бүрэн барагдуулсан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын шалгалтаар улсын байцаагчийн актаар тавигдсан ажилгүйдлийн тэтгэмжийн 1310037 төгрөг, оршуулгын тэтгэмж 2,0 сая төгрөг, жа хчта 154878 төгрөг, үо хчта 4568152 төгрөг, үо тэтгэврийн 3779832 төгрөг нийт 11812899 төгрөгийн актыг төлбөрийг холбогдох даатгуулагчтай холбогдож 9011286 төгрөгийн актыг бүрэн барагдуулж 1407382 төгрөгийн актыг 6 сард багтаан төлүүлэх арга хэмжээ авч ажилласан бөгөөд үо тэтгэврийн актыг барагдуулалтыг сар бүр 50 хувийн суутгал хийж байгаа болно. Мөн НДЕГазраас ирсэн шалгалтаар УБҮ дээр тавигдсан 12110151 төгрөг актыг хугацаанд нь төлүүлэх арга хэмжээ авч бүрэн барагдуулсан.	2025.01.01-2025.06.30	82.5
<b>ЗОРИЛТ 2. "ДААТГУУЛАГЧДАД ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДАГУУ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙГ ТОГТООЖ, ОЛГОЛТОД ХЯНАЛТ ТАВЬЖ АЖИЛЛАХ</b>							
2.	2.1. Даатгуулагчаас ирүүлсэн тэтгэвэр тогтоолгох баримтыг цахим системд бүртгэн тэтгэврийг тогтоож, хяналтын шатанд хүргүүлэх.	Тэтгэвэр тогтоолгох баримтыг бүрэн хүлээн авч, тогтоож, хянуулсан байна.	Тэтгэврийн материалыг бүрэн гүйцэд хүлээн авч хуулийн хугацаанд цахим системд бүртгэн тогтоож олгосон байна.	Тэтгэвэр тогтоолт, олголтыг хуулийн хугацаанд үнэн зөв тогтоож олгосон байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар өндөр насны тэтгэвэр хортой, хүнд, хүүхэдээр, хэвийн төрлөөр нийт 33, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 5, тахир дутуугийн тэтгэвэр 9, цэргийн тэтгэвэр 2, үо-ын тахир дутуугийн тэтгэвэр 3 нийт 52 иргэний ттгэвэрийн холбогдох материалыг хүлээн авч, зөвлөгөө өгч, шаардлагатай тохиолдолд архивын лавлагааг гаргуулан хүлээн авч, тэтгэврийг тогтоон SICOS програмд тухай бүрд нь мэдээллийг оруулж хяналтын байцаагчаар хянуулан олгосон. Хагас жилийн байдлаар нийт 31 даатгуулагчдаас архивын лавлагаа авах хүсэлтийг хүлээн авч холбогдох материалыг Хэнтий аймгийн НДГазар болон холбогдох аймгийн НДГазарт хүргүүлсэн үүнээс 17 даатгуулагчийн лавлагааны хариуг олгох үйлчилгээг хүргэж ажилласан байна.	2025.01.01-2025.06.30	100

<p>2.2.Тэтгэвэр авагчдын шилжилт хөдөлгөөнийг бүртгэн, хөдөлмөрийн чадварын алдалтын хувь хугацааг тогтоосон актыг хувийн хэрэгт хавсаргах.</p>	<p>Хувийн хэргийн бүрдэл байна.</p>	<p>Шилжилт хөдөлгөөнийг, тухай бүр бүртгэж, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоосон актыг хувийн хэрэгт хавсарган ажилласан байна.</p>	<p>Шилжилт хөдөлгөөнийг, тухай бүр бүртгэж, хувийн хэргийн бүрдэл сайжирсан байна.</p>	<p>Хөдөлмөрийн чадварын алдалтын хувь, хугацаа тогтоосон актыг сунгалт 75 тэтгэвэр авагчийн сунгалтыг хийж SICOS программд тухай бүрт нь оруулж олголт хийсэн байна. Шинээр сунгалт хийлгэж байгаа иргэдийн сунгалтын актыг тэтгэврийн хувийн хэргийн сканердсан хавтаст нэмж, эх хувийг хувийн хэрэгт хийж 2025.01.01-ны өдрийн нэмэгдлийг бичиж хувийн хэрэгт баяжилт хийсэн. 2025 оны эхний хагас жилд 5 даатгуулагчаас ирүүлсэн банк хооронд шилжих хүсэлтийг хүлээн авч программд бүртгэн өөрчлөлт оруулсан. Аймаг, дүүрэг, сум хооронд шилжих 3 иргэний хүсэлтийг хүлээн авч холбогдох баримт бичгийг үндэслэн шилжүүлэх хуудас бөглөн харьяа нийгмийн даатгалын газарт шилжүүлсэн. Нас барсан даатгуулагчийн хувийн хэргээс ажилласан жилийг тулгаж тогтоолтын хуудасыг нас барсан даатгуулагчид гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж болон дараа сарын тэтгэврийг олгохдоо хавсаргаж тэтгэвэр, тэтгэмжийн олголтын арын бүрдүүлэх материалыг бүрдүүлэн авч олголт хийхэд хяналт тавьж ажиллаж байна. Нийт нас барсан 28 тэтгэвэр авагчийн хувийн хэрэгт зогсоосон буюу нас барсны гэрчилгээг хавсарган хувийн хэргийг хааж хагас жилийн байдлаар архивт шилжүүлэхэд бэлэн болгож бүртгэл хөтөлсөн.</p>	<p>2025.01.01-2025.06.30</p>	<p>100</p>
<p>2.3. Тогтоогдсон тэтгэврийн хувийн хэргийг бүртгэж, тэтгэврийн төрөл дугаараар ангилан зориулалтын шүүгээнд хадгалах.</p>	<p>Зааврыг хангаж ажилласан байна.</p>	<p>Шинээр тогтоогдсон тэтгэврийн хувийн хэргийг хадгалалт, хамгаалалт зааврын дагуу хадгалагдсан байна.</p>	<p>Шинээр тогтоогдсон тэтгэврийн хувийн хэргийн хадгалалт, хамгаалалт зааврын хадгалагдсан байна.</p>	<p>2024.01.01-ны өдрөөс өмнөх өндөр нас 925, тд 130, та 85, үотд 231, үо та 35, 13362-1364 30, цэрэг 19 нийт 1455 хувийн хэргийг сканердаж хавтас үүсгэж хадгалсан. Бор-Өндөр сумын тэтгэвэр авагч 1507 даатгуулагчийн хувийн хэргийг төрөл дугаараар ангилан бүртгэж зориулалтын шүүгээнд хадгалан ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Өндөр насны тэтгэвэр авагч /2362/-958 даатгуулагч;</li> <li>• Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч /2364/- 139 даатгуулагч;</li> <li>• Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч /2363/- 90 даатгуулагч;</li> <li>• ҮОМШӨ Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч /4364/- 234 даатгуулагч;</li> <li>• ҮОМШӨ Тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч /4363/- 35 даатгуулагч;</li> <li>• Өндөр насны тэтгэвэр авагч-1995 оноос өмнөх /1362-1364/- 30 даатгуулагч;</li> <li>• Цэргийн алба хаасны тэтгэвэр авагч /3362-3364/- 21 даатгуулагч.</li> </ul> <p>2024 оны 01 дүгээр сарын 01-нээс хойш тогтоолт хийгдсэн иргэдийн материалыг тухай бүрд сканердаж Sicos программд бүрэн оруулж байсан бөгөөд хувийн хэргийн цахимжуулах ажил бүрэн хийгдсэн байна.</p>	<p>2025.01.01-2025.06.30</p>	<p>100</p>
<p>2.4. Эмнэлгийн байгууллагаас илгээсэн хөдөлмөрийн чадвар түр алдсан, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн хүсэлтийг цахим системд бүртгэн тооцож олгох.</p>	<p>Хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэнэ.</p>	<p>2143 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж , 138 даатгуулагчийн жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн хүсэлтийг цахим</p>	<p>Тэтгэмжийн тогтоолт, олголтыг хуулийн хугацаанд үнэн зөв тогтоож, олгосон байна.</p>	<p>2025 оны эхний хагас жилийн байдлаар эмнэлгийн байгууллагаас илгээсэн хөдөлмөрийн чадвар түр алдсан, ҮОМШӨ хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн хүсэлтийг даатгуулагч болон ажил олгогчоос ирүүлсний дагуу давхардсан тоогоор 872 даатгуулагчийн тэтгэмжийн материалыг хүлээн авч цаг хугацаанд нь олгож SICOS программд оруулан ажилласан. Үүнээс:</p>	<p>2025.01.01-2025.06.30</p>	<p>100</p>

		системд бүртгэн тэтгэмжийн тогтоолт, олголтыг хуулийн хугацаанд үнэн зөв тогтоож, олгосон байна.		<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж- 869 даатгуулагчийн 215,094.22 мянган төгрөг,</li> <li>ҮОМШӨ хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж- 3 даатгуулагчийн 19,119.45 мянган төгрөг,</li> <li>Жирэмсний болон амаржсаны тэтгэмж- 47 даатгуулагчийн 259,403.60 мянган төгрөгийн тэтгэмжийг тус тус даатгуулагчдад олгосон байна.</li> </ul> <p>Нийт 493,617.27 мянган төгрөгийн тэтгэмжийг тэтгэмжийн даатгалын сангаас олгосон бөгөөд олгогдоогүй болон хугацаа хэтрүүлсэн тэтгэмж байхгүй.</p>		
2.5. Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийг зохих баримтыг үндэслэн бодож олгох.	Хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэнэ.	51 даатгуулагчид нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг зохих баримтыг үндэслэн бодож олгосон.	Нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмжийг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэсэн байна.	2025 оны 01-06 дугаар сарын хугацаанд 16 иргэнээс нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хүсэлтийг хүлээн авсан бөгөөд холбогдох баримт бичгийг үндэслэн 32,000.00 мянган төгрөгийн тэтгэмжийг олгож, sicos программд мэдээллийг бүрэн оруулж бүртгэн, тогтоолтыг хийсэн байна. Арын баримт болох өргөдөл, иргэний үнэмлэх, НДДэвтэр, гэрчилгээний хуулбар, тогтоолтын хуудсыг сканердаж цаг тухай бүрд сангийн нягтлангийн мэйл хаяг руу явуулж гүйлгээг баталгаажуулж ажилласан.	2025.01.01-2025.06.30	100
2.6. Ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлтийг хүлээн авч, үндэслэлийг хянан цахим системд бүртгэн, тэтгэмжийн байцаагчид шилжүүлэх.	Хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх.	97 даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлтийг хүлээн авч, үндэслэлийг хянан цахим системд бүртгэн, хуулийн хугацаанд үнэн зөв тогтоож олгосон байна.	Ажилгүйдлийн тэтгэмжийг хуулийн хугацаанд үнэн зөв тогтоож олгосон байна.	2025 оны хагас жилийн байдлаар нийт 36 даатгуулагчаас ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлтийг цахимаар буюу portal.ndaatgal.mn программаар хүлээн авч, үндэслэлийг хянан цахим системд бүртгэн 223,682.83 мянган төгрөгийн тэтгэмжийн тогтоолт хийсэн байна. Ажилгүйдлийн тэтгэмжийн санхүүжилт хүрэхгүй байгаатай холбоотойгоор өмнөх оны олгогдоогүй ажилгүйдлийн тэтгэмж болон 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийг хүртэлх 70 даатгуулагчийн 265,011.98 мянган төгрөгийн тэтгэмжийг олгосон байгаа бөгөөд 31 даатгуулагчийн 134,294.19 мянган төгрөгийн тэтгэмж олгогдохоор хүлээгдэж байна.	2025.01.01-2025.06.30	80
2.7. Эрүүл мэндийн даатгалын хураамжийг хэрхэн төлөх талаар даатгуулагчдад зөвлөн туслах.	НДЕГ, ЭМДЕГ-ын хамтран ажиллах гэрээний дагуу.	Эрүүл мэндийн даатгалын хураамжийг ebarimt application-р төлөх талаар, иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээллийг хүргэсэн байна	Эрүүл мэндийн даатгалын хураамжийн талаар, иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээллийг хүргэсэн байна.	Эрүүл мэндийн даатгалын хураамжийг e-mongolia болон e-barimt application-аар төлөх зааврыг 107 даатгуулагчид өгсөн, төлөгдөөгүй байгаа эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийн дүнг 39 даатгуулагчид тооцож өгсөн, мөн эрүүл мэндийн даатгалтай холбоотой аливаа асуудлыг /ЭМДЕГ-ийн 18001363, Хэнтий аймгийн ЭМДХэлтэсийн 70562001/ утсаар лавлан асуух талаар зөвлөгөөг хүргэж ажилласан.	2025.01.01-2025.06.30	100
2.8. Нийгмийн даатгалын үйлчилгээг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон бусад байгууллага, багийн засаг дарга нартай хамтарч ажиллах.	Хамтран ажиллан үр дүнд хүрсэн байх.	Нийгмийн даатгалын үйлчилгээг хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн болон сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөний гэрээ байгуулан биелэлтийг хагас жилээр болон бүтэн жилээр хянуулж ажилласан.	Нийгмийн даатгалын үйлчилгээг хэрэгжүүлэх чиглэлээр Аймгийн засаг даргатай байгуулсан гэрээ биелсэн байх.	Нийгмийн даатгалын үйлчилгээг хэрэгжүүлэх чиглэлээр төрийн болон бусад байгууллага, багийн засаг дарга нартай дараах байдлаар хамтран ажилласан байна. Үүнд: <ol style="list-style-type: none"> <li>Нийгмийн даатгалын үйлчилгээг хэрэгжүүлэх чиглэлээр аймгийн болон сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөөний гэрээ байгуулан ажилласан.</li> <li>Сайн дурын даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Бор-Өндөр сумын хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтнээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эх, эцгийн судалгааг гаргуулж даатгуулагчийн шимтгэл төлөлтийг шүүн ажил хөдөлмөр эрхлээгүй байгаа даатгуулагчидтай холбогдон шинээр 2</li> </ol>	2025.01.01-2025.06.30	100

				<p>эхийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эх, эцгийн сайн дурын даатгалд хамруулсан.</p> <p>3. Бор-Өндөр суманд бүртгэлтэй малчин 161 өрхийн судалгааг Засаг даргын тамгын газраар гаргуулж нийт ажилласан жил болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг шүүж үзэн 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан малчид, хоршоологчдын зөвлөгөөнд оролцохдоо тэтгэвэр тогтоолгох нөхцөл, шаардлагыг танилцуулж, сонирхсон иргэдэд ажилласан жилийг мэдэгдэн шаардлагатай тохиолдолд сайн дурын даатгалд хамрагдах талаар зөвлөгөө мэдээллийг өгсөн.</p> <p>4. Бор-Өндөр сумын 6 багийн засаг даргатай хамтран 2025-2027 онд тэтгэвэр тогтоолгох 55 настай эмэгтэй /1970, 1971, 1972 оны/, 60 настай эрэгтэй /1965, 1966, 1967 оны/, 4 буюу түүнээс дээш хүүхэдтэй 50 настай эмэгтэй /1975, 1976, 1977 оны/ нийт 336 иргэний судалгааг гаргуулан авсан.</p> <p>5. Эрдэнэс критикал минерал ТӨҮГ-ийн харьяа Бор-Өндөр УБҮ-тай хамтран 2025-2027 онуудад газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлөөр болон 4 буюу түүнээс дээш хүүхэдтэй хүүхдийн нөхцөлөөр, тэтгэвэр тогтоолгох 183 даатгуулагчдын судалгааг гаргуулан авсан.</p>			
<b>Зорилт 3 “ Байгууллагын болон нэгжийн дотоод үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тайлагнах”</b>							
3.	3.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, бусад мэдээг тухай бүр гаргаж удирдлагад танилцуулж байх.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна.	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хагас жилээр болон бүтэн жилээр гаргаж тайлагнасан байна.	Хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг хугацаанд нь гаргаж тайлагнасан байна.	Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн. Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 4.1. “Албан хаагч төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн тайлангийн загварын дагуу хагас жилээр 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор тайлагнана” гэж заасны дагуу журамд заасан хугацаанд багтаан тайлагнасан.	2025.01.01-2025.06.30	100
	3.2. Даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, албан бичигт хариу төлөвлөж өгөх .	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, албан бичигт дор бүр нь хариу өгч шийдвэрлэсэн.	Шаардлагатай судалгаа, тайлан мэдээг шийдвэрлэсэн хугацаанд нь дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.	Даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, албан бичигт дор бүр нь хариу өгч шийдвэрлэсэн. Шаардлагатай судалгаа, тайлан мэдээг шийдвэрлэсэн хугацаанд нь дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Мөн 7056212212 утсаар иргэдээс ирүүлсэн мэдээлэл хариу өгч асуудлыг тухай бүрд нь шийдэж ажилласан бөгөөд нийт 132 даатгуулагчид мэдээллийг хүргэсэн.	2025.01.01-2025.06.30	100
	3.3. Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллах үүрэг хүлээх .	Аливаа мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажилласан байна.	Ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу ажил олгогч, даатгуулагчийн нууцыг задруулахгүй ажилласан байна.	Ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу ажил олгогч, даатгуулагчийн	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлд заасан нийгмийн даатгалын байцаагчид хориглох зүйл заалтууд болон Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийн 5.2.4. “албан үүргээ гүйцэтгэж байхдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхлын	2025.01.01-2025.06.30	100

			нууцыг задруулахгүй ажилласан байна.	төлөө ашиглах, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх" зэрэг заалтуудыг чанд баримтлан ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу ажил олгогч, даатгуулагчийн нууцыг задруулахгүй ажиллах үүргээ биелүүлсэн байна.		
3.4. Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг дагаж мөрдөж ажиллах.	Стандарт, зааварт нийцүүлэн ажилласан байна.	Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг өдөр тутмын үйл ажилагаандаа мөрдлөг болгон ажилласан байна.	Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг өдөр тутмын үйл ажилагаандаа мөрдлөг болгон хэвшсэн байна.	Албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг өдөр тутмын үйл ажилагаандаа мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн байна.	2025.01.01-2025.06.30	100
3.5. Тайлант хугацааны ажил олгогчийн даатгалын шимтгэлийн тайлан, зогсоогдсон хувийн хэрэг болон бусад баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивд хүлээлгэн өгөх.	Архив, бичиг хэрэг хөтлөлтийн зааврын баримтлан ажиллана.	Тайлант хугацааны ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан-12 боть, зогсоогдсон тэтгэврийн 85 хувийн хэрэг болон бусад баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивд хүлээлгэн өгсөн.	Архивын материалыг цаг тухайд нь хүлээлгэн өгч албан хэрэг хөтлөлт, архивын баримт холбогдох стандарт, зааварт нийцүүлэн ажилласан байна.	2024 оны НДШ-ийн НД7,8 тайланг өмчийн хэлбэр, ажил олгогчийн бүртгэлийн дугаар, нэр, он, сараар, СДД-ын гэрээг цагаан толгойн үсгийн дараалал оноор ангилан төрөлжүүлж архивт хүлээлгэн өгөх хугацаандаа буюу 2025 оны 02 дугаар сарын 24-ны дотор хэнтий аймгийн нийгмийн даатгалын газарт хүргүүлсэн. 2025 оны ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, зогсоогдсон өндөр насны тэтгэвэр авагч-11 хувийн хэрэг, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр авагч- 12 хувийн хэрэг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч- 5 хувийн хэрэг болон бусад баримтыг хадгаламжийн нэгж үүсгэн архивд хүлээлгэн өгөхөөр албан хэрэг хөтлөлт, архивын баримт холбогдох стандарт, зааварт нийцүүлэн бүртгэл хөтлөн хадгалж байна.	2025.01.01-2025.06.30	100
3.6. Ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах.	Ашиг сонирхлын зөрчилгүй ажилласан байна.	Авлигын тухай, нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хоёр удаагийн сургалтанд хамрагдсан.	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 4 удаагийн сургалтад хамрагдаж, зөрчилгүй ажилласан байна.	Өдөр тутмын үйл ажиллагаандаа Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг мөрдлөг болгон ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж зөрчилгүй ажиллаж байна. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад 1-6 сарын хугацаанд хамрагдаагүй хэдий ч хууль журмыг судлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж байна.	2025.01.01-2025.06.30	100
3.7. Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч /ажилтан/-ын үйлчлүүлэгчтэй харилцах журам"-ыг мөрдлөг болгон ажиллах.	Журмыг мөрдөж ажилласан байна.	Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч /ажилтан/-ын үйлчлүүлэгчтэй харилцах журмыг өдөр бүр үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн байна.	Нийгмийн даатгалын байгууллагын байцаагч /ажилтан/-ын үйлчлүүлэгчтэй харилцах журмыг мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн байна.	Ажил үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа: 1. Үндсэн хууль; 2. Хөдөлмөрийн тухай хууль; 3. Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга 4. Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм; 5. Нийгмийн даатгалын улсын байцаагчийн дүрэм; 6. Төрийн албаны тухай хууль; 7. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийг өдөр бүр үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн байна.	2025.01.01-2025.06.30	100
3.8. Удирдлагаас өгсөн бусад үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх.	Удирдлагаас өгсөн бусад үүрэг	Удирдлагаас өгсөн, бусад үүрэг даалгавар болон цаг үеийн	Удирдлагаас өгсөн, бусад үүрэг даалгавар болон цаг	Удирдлагаас өгсөн, бусад үүрэг даалгавар болон цаг үеийн байдлаас шалтгаалсан ажлыг заасан хугацаанд бүрэн биелүүлэн ажилласан байна. Үүнд:	2025.01.01-2025.06.30	100

		даалгаврыг биелүүлсэн байна.	байдлаас шалтгаалсан ажлыг заасан хугацаанд бүрэн биелүүлэн ажилласан.	үеийн байдлаас шалтгаалсан ажлыг заасан хугацаанд бүрэн биелүүлэн ажилласан байна.	<ul style="list-style-type: none"> <li>• Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийг зар мэдээ болон албаны мэйл хаягаар хүлээн авч танилцан хэрэгжлүүлэн ажиллаж байна.</li> <li>• Тэтгэврийн тооллого хийх тухай албан бичгийн дагуу тэтгэврийн тооллого хийх комисс томилуулан тооллогыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэн хүргүүлсэн.</li> <li>• Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хэнтий аймгийн нийгмийн даатгалаас ирүүлэхээр зааварласан тоон мэдээлэлийг цаг тухай бүрт хүргүүлсэн.</li> <li>• Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Хэнтий аймгийн нийгмийн даатгалын газрын фэйсбүүк хуудаст тавигдсан мэдээ мэдээллийг цаг тухай бүрт тасгийн фэйсбүүк хаягт болон Бор-Өндөр сумын зарын группт хуваалцан түгээсэн.</li> </ul>		
--	--	------------------------------	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Эхэлсэн, дууссан хугацаа	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6		7
1.	Монгол бичгийн чадварт суралцах	Үндэсний бичиг соёлоо мэддэг, уншиж бичих чадвартай болох.	Монгол бичгийн дунд шатны сургалтад хамрагдсан.	Унших чадвар сайжирсан байх, сургалтад хамрагдах.	Монгол бичгийн дунд шатны сургалтаар эзэмшсэн мэдлэг чадвараа бататган унших, бичих чадвараа сайжруулж байна.	2025.01.01-2025.06.30	100
2.	Хууль тогтоомжийн өөрчлөлттэй тухай бүр танилцаж мэдлэг чадвараа дээшлүүлэх, зохион байгуулсан сургалтад хамрагдах	Сургалтад хамрагдсан тоо Мэдлэг чадвараа дээшлүүлсэн байдал.	Хууль тогтоомжийн өөрчлөлттэй тухай бүр танилцаж хуулийн шинэчлэлийн талаарх НДЕГ, ТАЗ болон хэнтий аймгийн НДГазраас зохион байгуулсан цахим болон танхимийн нийт таван удаагийн сургалтад хамрагдсан.	Хууль тогтоомжийн өөрчлөлттэй тухай бүр танилцаж мэдлэг чадвараа дээшлүүлэх, зохион байгуулсан сургалтад хамрагдах.	Хууль тогтоомжийн өөрчлөлттэй тухай бүр танилцаж хуулийн шинэчлэлийн талаарх НДЕГ, ТАЗ-ын Хэнтий аймаг дахь салбар зөвлөл, хэнтий аймгийн НДГазраас зохион байгуулсан цахим болон танхимийн нийт 19 удаагийн сургалтад хамрагдсан. Үүнд: 1. Sicos программд тэтгэврийн тайлан гаргах талаар 2025.01.21 2. Sicos программд шимтгэлийн тайлан гаргах талаар 2025.03.01 3. Sicos программд тэтгэврийн тайлан гаргах талаар 2025.03.01 4. "Нэг цаг, нэмэх цэнэг" Хүний эрх, эрх чөлөө 2025.03.13 5. "Нэг цаг, нэмэх цэнэг" Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа 2025.04.03 6. "МЭДЭЭЛЛИЙН ЦАГ" НДШ төлөгчид бүртгэлийн дугаар олгох, хэрэглэх болон хувийн хэрэг нээх, бүртгэл хөтлөх, шилжүүлэх журам 2025.04.04 7. "Нэг цаг, нэмэх цэнэг" Стресс менежмент 2025.04.10 8. "МЭДЭЭЛЛИЙН ЦАГ" илүү төлсөн шимтгэлийг буцаах журам 2025.04.11	2025.01.01-2025.06.30	100



					<p>9. "МЭДЭЭЛЛИЙН ЦАГ" Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал 2025.04.18</p> <p>10. "МЭДЭЭЛЛИЙН ЦАГ" Нийгмийн даатгалын багц хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмыг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал 2025.04.25</p> <p>11. Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах сургалт НДЕГ 2025.04.28</p> <p>12. Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг чадавхижуулах сургалт НДЕГ 2025.04.29</p> <p>13. "МЭДЭЭЛЛИЙН ЦАГ" Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах журам 2025.05.02</p> <p>14. "МЭДЭЭЛЛИЙН ЦАГ" Ажил олгогчид үзүүлэх хөнгөлөлт, түүнийг тодорхойлох 2025.05.09</p> <p>15. Мэдээллийн аюулгүй байдал, "Албан бичиг хэрэглээний дундын систем", "Тоон гарын үсгийн хэрэглээ" 2025.05.09</p> <p>16. "НЭГ ЦАГ, НЭМЭХ ЦЭНЭГ" Төрийн албан хаагчийн ёс зүй 2025.05.15</p> <p>17. "НЭГ ЦАГ, НЭМЭХ ЦЭНЭГ" Хөдөлмөрлөх эрх 2025.05.15</p> <p>18. "Нийгмийн даатгалын байгууллагын авлагын менежмент, авлагыг барагдуулах арга зам" 2025.05.16</p> <p>19. "МЭДЭЭЛЛИЙН ЦАГ" Нийгмийн даатгалын цахимжилт 2025.05.23</p>		
3.	Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн цахим систем Sicos программыг бүрэн ашиглаж хэвших.	Sicos программд бүрэн ажиллах чадвартай болсон байх.	Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системд бүрэн ажиллаж сурсан байна.	Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн цахим систем Sicos программыг өдөр тутамдаа бүрэн ашиглан ажиллаж байна. Тус системээр дамжуулан даатгуулагч болон ажил олгогчийн мэдээллийг бүртгэх, засварлах, тэтгэвэр тэтгэмжийн хүсэлтийг хүлээн авч бүртгэх, тогтоолт хийх, ХЧА-ын хугацаа сунгалт хийх, тэтгэврийн 1,5 болон 20-ын нэмэгдэл хийх, тэтгэвэр авагч болон ажил олгогч байгууллагын шилжилт хөдөлгөөнийг хийх, ажил олгогчоос ирүүлсэн НДШ тайланг хүлээн авч хянах, тэтгэвэр тэтгэмжийн олголт үүсгэх, тэтгэвэр тэтгэмжийн олголт, тайланг тулгах, СДД-ын гэрээ байгуулах, орлого шүүх, албан журмын болон сайн дурын даатгалын цалин засах зэрэг үйлдлүүдийг өдөр тутмын ажилдаа хийн гүйцэтгэж хэвшсэн байна.	2025.01.01-2025.06.30	100.	

ТАЙЛАН ГАРГАСАН:

БОР-ӨНДӨР СУМЫН НИЙГМИЙН  
ДААТГАЛЫ ТАСГИЙН ДАРГА  
(Албан тушаал)



/С.БАТЦЭНГЭЛ/

(Нэр, гарын үсэг)

АЛТН-1252

2025.05.31

(Огноо)